

ДОРНОД МОНГОЛЫН НЕОЛИТ, ХҮРЭЛ, ХҮННҮГИЙН ҮЕИЙН ОРШУУЛГЫН ЗАН ҮЙЛИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Г.Батхишиг

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи-Археологийн тэнхим, магистр

Түлхүүр үг: булш, оршуулгын зан үйл, бүтэц, неолит, хүрэл, хүннү,

Монгол орны үе үеийн соёлд холбогдох дурсгалууд (хадны сүг зураг, хөшөө дурсгал, хот суурин, түүвэр олдвор, булш оршуулга, түүнээс гарсан эд өлгийн зүйлс)-ыг эрдэмтэд харьцуулан судалж, өөр өөрийн дүгнэлтүүдээ өгсөөр байгаа бөгөөд гагцхүү оршуулгын байгууламжийг тусад нь авч түүний бүтэц, зохион байгуулалт, зан үйл, түүнд гарсан өөрчлөлт, хөгжил дэвшил, холбоо хамаарлыг Монголын материал дээр хөндөн тавьсан нь өнөө хир ховор байна. Тийм ч учраас энэхүү сэдвийг бид сонгон авч неолит, хүрэл, хүннүгийн булш оршуулгын байгууламж, оршуулах зан үйл хэрхэн хувьсан өөрчлөгдсөнийг судлах оролдлого хийлээ. Энэхүү судалгаанд нь нэг бүс нутаг өөрөөр хэлбэл Дорнод Монголын булш оршуулгуудыг сонгон авлаа. Учир нь энэ бүсээс неолит, хүрэл, хүннүгийн аль аль үеийнх нь шинж төрхийг харуулсан булш оршуулгууд олдсон бөгөөд энэ нь судалгааны зорилготой нөхцөлдөж байгаа юм.

Уг судалгаанд Дорнод Монголын нутагт малтан судалсан Неолитийн 5, Хүрлийн 80 гаруй, Хүннүгийн 11 нийт 100 орчим булшны өгөгдөхүүнийг авч ашиглалаа.

Судалгааг хийхийн тулд булшны материалуудыг ижил нөхцөлтэй нэг хүснэгтэд оруулаад тэндээсээ харьцуулалт хийж дүгнэлт гаргаж авахыг зорилоо. Тэгэхдээ неолит, хүрэл, хүннүгийн гэсэн 3 үндсэн үеийг хооронд нь харьцуулсан бөгөөд булшнуудаа ижил төсөөтэй ялгаатай талаар нь тоон хэмжүүрт оруулан жишихэд голлон анхаарсан.

Харьцуулсан хүснэгтээс үндэслэн дараах дүгнэлтүүдэд хүрч болохоор байна.

1. Булшны гадаад дотоод зохион байгуулалт, хэмжээ

1.1. Булшны гадаад зохион байгуулалт

Гадаад зохион байгуулалтын хувьд хоорондоо эрс ялгаатай байна. Тухайлбал: Неолитийн үед гаднах шинж тэмдэг гээд мэдэгдэхээр зүйл үлдээдэггүй байсан бол хүрлийн үе болоход булшны гадаад зохион байгуулалтыг илүүтэй анхаарах шинжтэй болж ирж байна. Тодруулбал дөрвөлжин хэлбэртэй, дөрвөн өнцөг эсвэл, нэг өнцгийн чулуу бусдаасаа өндөр, зарим нь ойролцоо газар хөшөөтэй гэх мэт. Харин Хүннүгийн үе болж ирэхэд гадаад зохион байгуулалт нь дугуй, дугуйвтар цагираг хэлбэртэй чулуу овоолсон байгууламж болж хувирч байна. Энэ нь дөрвөлжин булштай харьцуулахад өөр байгаа бөгөөд 1-рт дөрвөлжин булш нь голдоо ямар нэг хамгаалах чулуугүй байсныг боловсронгуй болгож буй хэлбэр 2-рт дөрвөлжин булшны байгууламжийг хийснээс энэхүү чулуун овоот булшны байгууламж илүү нарийн төвөгтэй 3-рт дөрвөлжин булшны соёлын уламжлалаас гадна чулуун овоот булшны уламжлал тусч байсантай тус тус холбон тайлбарлаж болох юм. Хүннүгийн үеийн судалгаанд хамрагдсан булшуудаас 1998 онд малтсан Дэлгэрхааны 1-р булш гадаад зохион байгуулалтын хувьд дөрвөлжин хэлбэртэй байгаа нь хүрлийн үеийн дөрвөлжин булшныхтай төсөөтэй байна. Энэ нь 2 соёлын хооронд ямар нэг холбоо байгааг илтгэж байна. Зарим судлаачдын үзсэнээр Хүннү булш голдуу дөрвөлжин хэлбэртэй тонуулчдын үйл ажиллагаагаар гадаад төрх байдал дугуй хэлбэртэй болж өөрчлөгдсөн гэж үзэх үзэл байна. Энэ нь энэхүү судалгаанд хамрагдсан булшны материалаар няцаагдаж байгаа бөгөөд археологич З.Батсайхан Хүннү булшинд дугуй хэлбэр зонхилж байсан гэж үзээд Дэлгэрхаанд малтсан тоногдоогүй булшны материалаар жишээ болгосон байна.

Мөн судалгаанд хамрагдсан хүннү булшны ихэнх нь дугуй, тал дугуй хэлбэртэй байгаа нь бүс нутгийн өвөрмөц онцлог байхыг үгүйсгэж болохгүй юм.

Мөн Хүннүгийн булшны байгууламж нь их хэмжээний том том чулуу овоолсон байгууламж болж хувирч байгаа нь булшны бөх батыг илүүтэй бодсон бас тухайн үед нүүдэлчдийн нийгэмд төр улс үүссэнтэй холбоотой социал бүтцийн ялгаа гарч байсантай холбоотой. Өөрөөр хэлбэл Хүннүгийн үед төр улс үүссэнтэй холбоотой тэдний оюун санаа болон хөдөлмөрийн багаж зэвсэгт дэвшилт гарсан нь нийгэмд ялгарал бий болох үндэс болсон гэж үзэж болохоор байна.

1.2. Булшны дотоод зохион байгуулалт

Дотоод зохион байгуулалтын хувьд неолитийн үед шууд хөрсөнд нь ямар нэг хамгаалах хэрэгсэлгүй өөрөөр хэлбэл авсгүй оршуулдаг байсан бол хүрлийн үе рүү шилжихэд зарим булшиндаа чулуун хашлага хийх, чулуун дараас тавих зэргээр авс маягийн байгууламж үлдэх болсон тал ажиглагдаж байгаа бөгөөд жишээ болгож Сөөгийн ам 1, Долоод 17, Устын амны 1-р булшуудыг дурдаж болж байна. Баянцогтын 1-р булшинд бүр модон хашлага хэрэглэсэн байна.¹ Мөн чулуун дараасандаа "цоож" хийх зэргээр бат бөх болгох аргыг эрэлхийлж байжээ. Баримтуудаас үндэслээд хүрлийн үед булшиндаа гаднах чулуун хашлаганы дотуур давхар чулуун хашлага хэрэглэх болж энэ нь цааш хөгжин Хүннүгийн үед авс хэрэглэх заншлын эх суурь болжээ гэж үзэх үндэстэй.

Харин Хүннүгийн үе рүү шилжихэд тусгайлан бэлдсэн мод, чулуугаар хашлага авс хийж таг тавьдаг болжээ. Хүннүгийн судалгаанд хамрагдсан бараг бүх булшинд энэ зохион байгуулалт ажиглагдаж байгаа бөгөөд өөрөөр хэлбэл авс зайлшгүй байх ёстой зүйл болжээ. Хүннүгийн үеийн модон австай булшны таглаа нь өнгө будаг хээ хуартай модоор хийсэн нилээд чамин хийц бүхий байгууламж болж байгаа бөгөөд Дуулга уулын хэд хэдэн булшнаас ийм хээ хуар бүхий модоор таг тавьж байсан шинж тэмдэг илэрч байгаагаас ийнхүү дүгнэлт хийхэд хүрч байна. Гэхдээ Дэлгэрхааны булшууд чулуун авс, хашлагатай түүндээ чулуун дараас хэрэглэсэн байгаа бөгөөд хэрэглэгдэхүүнээс үзэхэд мод ихтэй хангай газарт банзан авсыг түлхүү хэрэглэж байсан бол хад чулуу ихтэй хангайгаас зайдуу газар хавтгай хадыг илүү хэрэглэж байсан бололтой. Энэ нь Хүрлийн үеийн чулуун хашлага хийх арга барилыг санагдуулж байгаа бөгөөд Хүннүд уламжлагдсан боловч аажим аажмаар ач холбогдлоо алдсан гэж үзэж болох үндэстэй. Бас модон болон чулуун шалыг авсандаа хэрэглэх болсныг харж болно.

Оросын нэрт археологич Конавалов судлаад чулуун хашлагатай дөрвөлжин булшийг Хүннү булштай адилтгаж үзээд Хүннү булшны анхны хэлбэр нь дөрвөлжин булш мөн гэсэн дүгнэлтийг өгсөн бөгөөд уг судалгаанд байгаа давхар чулуун хашлагатай дөрвөлжин булш, Хүннүгийн чулуун хашлагатай булшны хооронд адил төстэй зүйл байгаа нь дээрх үзэл баримтлалыг баталж байна.

Мөн нэг зүйлийг тодруулахад таглаас чулуутай булш хүрлийн үед бүх булшинд дайралдахгүй байгаа ба Хүннүгийн үе рүү шилжихэд бараг бүх булшинд шахуу чулуу болон модон таг хийсэн байгаа нь хүрлийн үед үүсээд Хүннүгийн үед нилээд өргөн дэлгэр болсон арга барил бололтой. Чулуун таглаас Хүннүгийн зарим булшнаас ажиглагдаж байгаа ба ялангуяа Дэлгэрхааны булшуудад чулуун таглаас олон ажиглагдаж байгаа нь чулуун таглаас нь хүрлийн соёлоос Хүннүд уламжлагдаж байгаа нь чулуун таглаас нь хүрлийн соёлоос Хүннүд уламжлагдаж байгааг харуулж байна.

Эндээс үзэхэд булшны зохион байгуулалт сүүл үерүүгээ нилээд боловсронгуй болж байгааг харж болохоор байна. Неолитийн үед хамгаалах байгууламжгүй шууд оршуулдаг жинхэнэ модон чулуун австай, нилээд том хэмжээний чулуу овоолсон нарийн төвөгтэй байгууламж болж өөрчлөгдсөн нь нэг ёсны дэвшил ажиглагдаж байна.

¹ Д.Наваан "Дорнод монголын хүрлийн үе" УБ, 1975

Гадаад зохион байгуулалт	Дотоод зохион байгуулалт	Хэмжээ	Гүн	Зүг	Хүнээ тавилт	Дагалдуулсан эд өлөг	Зан үйл	
Мэдэгдэхгүй	Мэдэгдэхгүй	Диаметр -1,2 м -80 см -58x41см	90 см- ээс 2м	Зүүн-3 Бар-1 Үл-1	Суугаа байдал -тай бохир- уулж	-Гоёл чимэглэл /танан сувс, цагаан сувс, бугын шүдэн зүүлт, танан чимэг, ясан бугуйвч бодонгийн болон тарваганы соёо, шүдээр хийсэн зүүлт г.м./ -Өдөр тутмын хэрэгцээний эд өлөг /Зуулга иртэй ясан хутга, эврээр хийсэн жижиг хүрз, / -Шүтлэг бишрэлтэй хобоотой /Чулуун онго/	Улаан зос цацах заншил	Н е о л и т
Дөрвөлжин хэлбэртэй чулуун байгууламж болж хувирсан. 4 өнцөгтөө өндөр чулуу эсвэл 1,2 өнцгийн чулуу өндөр, зарим нь хөшөөтэй. Голдуу толгой талын заримд нь бусад талын хана чулуу их урт том.	Зарим булш авс маягийн чулуун эсвэл модон хашлагатай. Чулуун таглаас хэрэглэсэн булшууд ч байна. Таглаас чулуундаа "цоож" маягийн зүйл хэрэглэсэн булш цөөнгүй байдаг. Ихэнхэд нь тийм зүйл ажиглагддаггүй.	2x3 –аас 5,6x7,5 м хэмжээ- тэй булш ч байна. Том нь Сөөгтэйн адгийн 1-р булш 5,6x7,5	0,6- 1,5 0,7	Зүүн 3 зүгийн аль нэг рүү тол- гойг харуул -сан.	Тэнэ- гэр голдуу Зарим нь хажуу- гаар Хамт 2 хүн оршуу- лсан булш байна.	-Хоол хүнс -Гоёл /танан болон цагаан шар сувс, хаш мана, номин, чон чулуу, хү/to / -А/а-н өдөр тутмын хэр/эд өлөг /ваар сав, хүлс, аяга/ -Ан гөрөө /ангийн яс, сумын зэв/ -Шүтлэг бишрэл, зан үйлтэй холбоотой /цахиур, шувууны модон толгой/	-Улаан шарзос -Дэр ивүүр -гал түлсэн ором -Гал төлөөл- үүлсэн /цах. Хүлс/ -Хүнээ аль нэг хананд тулгаж ор-сан.	Х ү р э л
Том том чулууг дугуй хагас дугуй хэлбэрээр овоолсон чулуун байгууламж, Нэг булшинд дөрвөлжин хэлбэрээр зассан байна. Дэлгэрхаан 1998-1-р булш	Модон ба чулуун авс, модон ба чулуун дараас буюу таглаастай. Аль алиныг нь хослуулсан ч байна. Модон таг нь хээ угалз өнгө ялганхээлсэн гоёмсог.	3,5x4,5 м диаметр 16 м	2-6 м	Хойд 8 Баруун хойш-1 Зүүн урагш 2 /?/	Тэнэ- гэр байд- лаар дээш харуу- лж Нэг бул- шинд суугаа байж болзош -гүй	-өдөр тутмын аж ахуйн хэр.зүйлс /ваар сав, хүрэл цар, ээрүүлийн таваг, х.тогоо/ -Хоол хүнс /малын яс будаа/ -Гоёл чимэг /алт, мөнгө, маргад эрдэнэ, чон чулуу, хүрэл толь, хээ/ төмөр, торгоны үлдэц/ Зэр зэвсэг, ан гөрөөний зүйл /Жадны гилбэр, хадаас, хөрөө, сүх, нумын бариул гичирийн наалт, бугын ясан эвэр -Адууны тоног хэрэгсэл /амгай дөрөө/ -Онцлог эд өлөг /Хөгжмийн зэмсэг/	Гал Түлсэн ором, юм шатсан- аас үүссэн нүүрс	Х ү н н ү

Энэ нь нийгмийн дэвшил түүнтэй холбогдсон хөдөлмөрийн бүтээмж, оюуны болон эдийн соёлын өөрчлөлт гарсаныг илтгэж байна /Зураг/

1.3. Булшны хэмжээ

Хэмжээний хувьд неолитийн үед диаметр нь 60-120 см байсан бол хүрлийн үе болж ирэхэд 2х3 м-ээс 5х7, Хүннүгийн үед 3.5х4.5 м-ээс 16 м диаметртэй маш том байгууламж болж хувирч байна. Үүнтэй холбоотой булшны гүн ч гэсэн үеэс үед өөрчлөгдсөөр байна. Неолитийн үед 0.7-2 м, Хүрлийн үед 0.6-1.5м, Хүннүгийн үед 2-6 м болж маш гүн нүх ухаж нас барагчийг оршуулах болжээ. (Хүннүгийн шаньюйгийн булш 18 м хүртэл гүнд байсныг археологич Д.Наваан олж тогтоосон байна Гэхдээ энэ нь судалгаанд хамрагдах бүс нутагт хамаарахгүй). Булш гүнзгий байх тусмаа бат бөх байхаас гадна тухайн үеийн оршин суугчдын эд хөрөнгийн тэгш бус байдал, нийгмийн социал бүтцийн ялгаа хүчтэй болж байснаар тайлбарлагдана. Энэ байдал Хүннүгийн үеэс хүчтэй илрэх болжээ. Үүнд нэг зүйлийг тодруулахад дөрвөлжин булшны хувьд тэр их чулууг зөөж авчираад тийм гоёмсог байгууламж байгуулж байгаа мөртлөө тийм өнгөц оршуулдаг байсан нь сонирхолтой бөгөөд үүнийг хөдөлмөрийн бүтээмжтэй холбон тайлбарлах нь учир дутагдалтай юм. Энэ нь дөрвөлжин булшны зохион байгуулалтанд хамгийн тохиромжтой гүн нь энэ байсантай ихээхэн холбоотой.

Булшны гадаад дотоод зохион байгуулалт, хэмжээ, гүний эдгээр ялгаатай байдал нь хоорондын залгамж холбоог үгүйсгэхгүй бөгөөд цаг хугацааны өөрчлөлтийг даган гарч ирдэг дэвшилтэй холбогдон тайлбарлагдаж болно. Гэхдээ тэдний хооронд ямар нэг залгамж холбоо байсныг гэрчлэх зарим нэг төсөөтэй шинжүүд ч байна.

2. Зүг эрхэмлэх заншил


Неолитийн үед хүнээ нүүрийг нь зүүн зүг харуулан оршуулах заншилтай байсан гэж үзэж болохоор байна. Учир нь энэ үед холбогдох 5 булшнаас 3-т нь хүнийхээ нүүрийг зүүн зүг, 1-д нь баруун зүг харуулан оршуулсан байгааг харж болж байна. Тамбсагбулагийн 1-р булшинд хүнийхээ нүүрийг баруун зүг харуулан оршуулсан байна. Хэрвээ зүүн зүгийг наран ургах зүг гэж үзвэл баруун зүг нь наран жаргах зүг тиймээс ч неолитийн үед энэ 2 зүгийн аль нэгийг эрхэмлэх ёс ажиглагдаж байна.

Харин хүрлийн үед бараг бүх булшинд зүүн 3 зүгийн аль нэг руу хүнийхээ толгойг харуулан оршуулж байгаа, зүүн аль нэг өнцөгт нь өндөр чулуу босгох, хөшөө босгосон байгаа зэрэг нь хүрлийн үеийн оршин суугчдын дунд зүүн зүг нилээд гол байсан тиймээс ч зүүн зүг харуулан оршуулах заншил тогтсон байжээ гэж үзэж болохоор байна. Эртний оршин суугчид наран ургах зүүн зүг, нарны илч гэрлийг эрхэмлэн үздэг байсантай холбоотой бололтой. Неолит, хүрлийн үед аль алинд нь зүүн зүгийг эрхэмлэн үзэж байгаа нь энэ 2 соёлын хооронд ямар нэг залгамж холбоо байгааг харуулж байна.


Хүннүгийн булшинд хойд зүг рүү толгойг нь харуулан оршуулсан нь нийтлэг байгаа бөгөөд үүгээрээ өмнөх 2 үеийн-соёлоос онцлогтой байна. Нийт 11 булшны материал хамрагдсанаас 8 нь хойд зүг, 1 нь баруун хойд зүг рүү толгойг нь чиглүүлэн тавьсан нь ажиглагдаж байна. Энэ нь ямар нэг зан үйл шүтлэгтэй холбоотой болох нь тодорхойгүй. Хятад сурвалжид тэмдэглэгдсэнээр "Хүннү нар зүүн зүгийг эрхэмлэнэ. Хойд зүг рүү харж сууна"¹ гэснээс үзэхэд зүүн зүг тэдний хувьд чухал үүгээрээ неолит, хүрлийн үетэйгээ холбоотойг харуулж байгаа боловч гагцхүү энэ нь судалгаанд хамрагдсан оршуулгын байгууламж дээр илрэлээ олоогүй байна. Сурвалжийн мэдээнээс үзэхэд Хүннү нарын хувьд зүүн зүгээс гадна хойд зүг бас нилээд эрхэм байжээ. Энэ нь оршуулгын байгууламж дээр илрэлээ олж байгаа бөгөөд магадгүй энэ заншил нь бусдаас содон гэрэлтэй алтан гадас од хойд зүгийн байнга заан оршиж байдагтай ч холбоотой үүссэн заншил

¹ Г.Сүхбаатар "Монголчуудын эртний евөг" УБ. 1981

Зураг



Сүхбаатар, Түвшинширээ
1997 он. 1-р Хүннү булш.



байж болох юм. Ямартай ч энэ заншил нь түүнийг өмнөх 2 соёлоосдо өвөрмөц шинжтэйг харуулж байна.

Гэтэл 1975 онд Дуулга ууланд малтсан 1-р булшинд нас барагчийг зүүн урагш, 1998 онд малтсан 2-р булшинд хүнээ зүүн тийш харуулан оршуулсан байж болох тал ажиглагдаж байна. 1998 онд малтсан булшинд 2 хүн оршуулсан шинж ажиглагдаж байгаа ба нэг хүний толгойг зүүн зүг чиглүүлэн тавьсан байж магадгүй байна. Энэ нь тухайн соёлуудын хооронд ямар нэг залгамж холбоо байгааг харуулж байгаа бөгөөд аажимдаа энэ заншил цаг хугацаны өөрчлөлтийг даган хувирсан бололтой. Тэгэхлээр ямартай ч Хүннүгийн үед хүнээ хойд зүг рүү харуулан оршуулдаг нийтлэг заншил тогтож байжээ гэж үзэж болохоор байна.

Нөгөө талаар өвөг Хүннүгийн гэж үздэг Маоцингоугийн булшуудын зонхилох чиглэл нь зүүн зүг байдаг талаар эрдэмтэд дурдсан байдаг. Энэ нь хүрэл ба Хүннүгийн соёлын уламжлалт чанарыг илтгэх бөгөөд Хүннү нар эхэн үедээ хүнээ зүүн тийш харуулан оршуулж байснаа түүхийн сүүл үерүүгээ өөрчлөгдсөн байж болох талтайг харуулж байна. Энэ тал дээр цаашид судалгаа хийх шаардлагатай байна.

Хүннүгийн зүг чигийг эрхэмлэх тал дээр гарч байгаа энэ ялгаа нь Хүннүгийн түүхэн нийтлэг бүрэлдэн тогтох явцад угсаа гарвалын хувьд төрөл ба төрөл бус олон овог аймгууд нэгдэн орсонтой холбоотой байж болох юм гэж үзжээ.²

3. Хүнээ тавих заншил

Нас барсан хүнээ суугаа байдлаар бохируулж нүүрийг нь зүүн зүг голцуу харуулан тавьдаг байжээ. Энэхүү хүнээ бохируулж оршуулж байгаа зан үйл бүх булшинд харагдаж байгаа бөгөөд энэ нь неолитийн үеийн оршуулах зан үйлийн онцлог шинж бололтой.

Зөвлөлтийн нэрт археологич С.В. Киселёв Хятадад судалгаа хийгээд "Баньпо хотын орчим дахь 200 гаруй булшинд суугаа оршуулга нэг ч байгаагүй"³ гэжээ. Харин Окладников, Ларичев, Киселёв нарын судалгаагаар Өвөр Байгальд нилээд олон ийм суугаа байдлаар оршуулсан оршуулга олдсон тухай дурдсан байна. Тэгэхлээр энэ нь Монголын неолитийн оршин суугчдын өвөрмөц маягийн заншил байсан бололтой бөгөөд түүнчлэн Америк, өмнөд Америкт суугаа байдлаар оршуулах зан үйл ихэд дэлгэрснийг судлаачид тогтоожээ.⁴ Неолитийн үед хүнээ суугаа байдлаар бохируулж оршуулж байгаа нь хүүхэд эхийнхээ хэвлийд байгаа байдлыг илтгэсэн бэлэгдэл гэж үздэг бөгөөд энэ нь хойд насандаа дахин төрөх болон үржлийн бэлэгдэлтэй холбоотой байж болох талтай. Өөрөөр хэлбэл газар эхэд нь эхийнхээ хэвлийд анх байснаар нь буцааж оршуулж байгаа хэлбэр бололтой. Ер нь неолитийн үед эмэгтэй хүн нийгэмд гол үүрэг гүйцэтгэж байсны илрэл болох гараа цондгор гэдсэн дээрээ тавьсан жирэмсэн эмэгтэйн мод, шавар, чулуун баримал булш, суурины малталтаас их олддогийг энд дурдаж болно.⁵ Харин хүрлийн үеийн ихэнх булшинд хүнээ тэнэгэр байдлаар оршуулсан байна. Энэ нь эхийн эрхт ёс үеэ өнгөрөөж байгаатай холбоотой бохируулж оршуулах ёс шахагдан гарснаар тайлбарлагдах бөгөөд тэнэгэр байдлаар оршуулах нь хүнээ харьцангуй тайван амгалан нойрсог гэсэн санааг илэрхийлж байна гэж үзэж болох талтай. Зарим нэг булшинд хүнээ хажуугаар нь харуулан оршуулсан тохиолдол байна.

² З.Батсайхан "Умард Хүннү ба нүүдлийн иргэншлийн хөгжил" МУИС. 2000. Докторын (Ph.D) диссертаци

³ С.В.Киселёв "Древняя история Южной Сибири" М.1951 /стр 192/

⁴ Д.Наваан "Эртний Монголын түүхийн дурсгалууд" УБ. 1980/33-р тал/

⁵ А.П.Окладников "Неолит и бронзовый век Прибайкалья" М.1955 /стр 84/

Хүннүгийн үе рүү шилжихэд тэнэгэр байдлаар оршуулдаг хүрлийн заншил хэвээр хадгалагдсаар байсан бөгөөд судалгаанд хамрагдсан¹¹ булшны материалаас харахад 1-ээс бусад нь бүгд тэнэгэр байдлаар оршуулсан байгаа нь харагдаж байна. Нас барсан хүнийг тавихдаа хөлийг жийлгэн тэнэнгэр байдлаар тавьж гарыг бие дагуулах ба тохойгоор нугалсхийн аарцаг дээр байруулсан байдаг бөгөөд үүнээс өөр байдлаар тавьсан тохиолдол маш цөөхөн байдаг байна. Ер нь Хүннүгийн оршуулгууд ихээхэн тоногдож эвдэрсэн байдаг боловч анхны тавилтаасаа хөндөгдөөгүй аль нэг ясаар зүг, чиг тавилтын баримжааг тогтоох бололцоотой байдаг. Тэнэгэр байдлаар нас барагчийг оршуулах зан үйл нь хүрлээс Хүннүд дамжин уламжлагдсан заншил болохыг харж болох боломж олгож байна.

4. Эд өлөг дагалдуулах заншил

Нас барсан хүндээ ойр зуурын хэрэгцээний эд өлөг, хоол хүнс, шүтлэг бишрэлийн зүйлийг дагалдуулан оршуулж хойд насандаа элбэг дэлбэг байхыг бэлгэддэг зан үйл харагдаж байна. Энэ нь хойд насны тухай ойлголт үүссэн байсныг харуулж байгаа бөгөөд дагалдуулж буй эд өлгийн байдлаас нь тухайн үеийнх нь нийгмийн дэвшил, аж ахуйн хөгжил, хөдөлмөрийн бүтээмж зэргийг харж болох боломж олгодгоороо ач холбогдолтой байдаг. Нас барагсаддаа эдэлж хэрэглэж байсан гоёл чимэг, хувцас, хоол хүнс, зэр зэвсэг зэргийг нь дагалдуулах заншил бүр неолитийн үеэс эх үүсвэртэй болох нь неолитийн булшнуудаас гоёл чимэглэлийн чанартай янз бүр эд өлөг гарснаар тодорхой байна.

Харин неолитийн үед хүндээ ямар нэг МАА-н чанартай хоол хүнс дагалдуулаагүй байгаа нь сонирхолтой бөгөөд хүрлийн үед нүүдлийн МАА зонхилох салбар болохын хамт үүнийг дагалдан оршуулгын зан үйлд өөрчлөлт гарч, бод бог малын толгой болон бусад хэсгийг дагалдуулан оршуулах зан үйл бий болсон. Ялангуяа дөрвөлжин булшинд адууны толгой, дөрвөн шийр, дал мэтийг тавих өвөрмөц заншил дэлгэрсэн бөгөөд мөн хүннүүгийн оршуулгын зан үйлд дээрх байдал олонтаа ажиглагддаг. Үүнээс үзвэл Монгол нутагт оршин сууж байсан нүүдэлчдийн дунд адууг эрхэмлэн үзэх өвөрмөц шүтлэг бий болсон байжээ. Харин Хүннүгийн үе шилжихэд адууны яснаас гадна үхэр, богийн яс нилээд гарах болсон нь нүүдлийн мал аж ахуйн хөгжлийн төвшин, түүнчлэн Хүннүгийн бүрэлдэхүүнд оролцож байсан угсаатны бүтэц, бүрэлдэхүүнтэй холбоотой байж болохын зэрэгцээ неолитийн үед гарсан эвэртэй мал (бух) шүтэх шүтлэгийн уламжлал хүннүгийн үед дахин сэргэсэнтэй холбоотой байж болох талтай. Мөн өмнөх үеийн булшуудаас гарч байгаагүй адууны тоног хэрэгсэл болох амгай, дөрөө гарсан нь тэр үеэс эдгээрийг хэрэглэх болсныг гэрчлэх чухал баримт юм.

Гоёл чимэглэлийн зүйлийн хувьд неолитийн үед танан сувс, зөөлөн цагаан сувс, ясан эдлэл, буга, бодонгийн соёо шүд дагалдуулан оршуулсан байсан бол хүрлийн үеийн булшуудаас шар цагаан сувс, хаш, мана, номин, чон чулуун гоёл чимэглэл олноор дагалдуулсан нь ийм төрлийн гоёл чимэгтухайн үед илүүтэй их хэрэглэх болсныг гэрчилж байна. Харин Хүннүгийн үед алт, мөнгө, маргад эрдэнийн чулуу хэрэглэх болж дэвшил гарсан бөгөөд хүрэн шар чон чулуун зүүлт чимгийн зүйл олдож байгаа нь өмнөх хүрлийн үеийн гоёл чимэг хийх арга барил дараагийнхаа үед уламжлагджээ гэж үзэх боломж олгож байна. Неолит, хүрлийн үед адилхан сувс, танан эдлэл зонхилж байгаа бөгөөд энэ нь энэ 2 соёл бие биеэ залган авч харилцан нөлөөлснийг харуулж байна.

Дашрамд тэмдэглэхэд дөрвөлжин булш болон Хүннүгийн булш зарим хиргисүүрээс олдсон чон чулуун эрх, сувс, зүүлт нь ур хийц хэв маягийн хувьд өөр хоорондоо тун адилхан байдаг¹ гэж археологич Д.Наваан тэмдэглэсэн байна. Үүнээс үндэслээд дөрвөлжин булшны соёлынхон ба Хүннү нар соёлын хувьд залгамж холбоотой гэж үзэж болохоор байна.

¹ Д.Наваан "Дорнод Монголын хүрлийн үе" УБ.1975 (135-р тал)

Хүннүгийн үед өмнөх 2 үеэ бодвол шавар ваар савны урлал өндөр төвшинд гарч хөгжсөнийг батлах баримт бол Хүннүгийн бараг бүх булшнаас 1-5 ширхэг ваар гарч байгаа явдал. Энэ баримт нь Хүннүгийн үед ваар сав хийх тусгай мэргэжлийн гар урчууд бий болж ваар савыг бөөнөөр хийдэг болсныг харуулж байна. Хүрлийн үед ч гэсэн нас барагсаддаа ваар сав дагалдуулах заншил байсаар байсан бөгөөд энэ нь хүрлийн ихэнх булшнаас шавар ваар сав, хүлсний хагархай олдож байгаагаас тодорхой байгаа бөгөөд Хүннүгийн ваар сав, хүлс дагалдуулах заншил нь хүрлийн үеэс эх үүсвэрээ тавьсныг харж болно.

Хүрлийн үеийн олон булшнаас цахиур гардаг бөгөөд неолитийн үеийн чулуун зэвсгийн өвөрмөц илэрхийлэл болсон цахиур хүрлийн үед уламжлагдан хадгалагдаж ирснээр эсвэл неолитийн үйлдвэрлэлийн арга барил ач холбогдлоо хараахан алдаагүй байснаар тайлбарлаж болно. Эндээс неолит, хүрлийн үед цаг хугацааны төдийгүй угсаа гарлын залгамж холбоо байж болохоор байна. Мөн түүнээс гадна тухайн үеийнхээ онцлог шинжийг харуулсан өвөрмөц эдлэлүүд олдож байгаа бөгөөд үүнд хээ хуар бүхий хөгжмийн зэмсэг Хүннү булшнаас, сумын хүрэл зэв зэрэг зүйлс Хүрлийн үеийн дөрвөлжин булшнаас гарч байгаа зэргийг дурдаж болно.

Хүрлийн үед холбогдох Устын амны 1-р булшнаас 50 см гүнээс хавтгай чулуун дээр жижиг чулуунуудын дунд хэдэн хэсэг болон хагарсан чулуун сав олдсоныг судлаачид аяга гэж үзжээ (толгой талаас олдсон). Уг савны диаметр 155 мм, өндөр 70 мм ба ёроол нь бөөрөнхий. Бариультай талын амсар нарийхан, бариулаас 2 тийш дугуйрсан хэсэгтээ бүдүүвтэр, нарийн хэсэгтээ амсрын зузаан 5-6 мм, дунд хэсэгтээ 10-13 мм, зузаан хэсэгтээ 30 мм орчим байна. Үүнтэй төсөөтэй цутгуурын шанагыг 1991 онд Хэнтий аймгийн Биндэр сумын нутаг Асгатын дөрвөлжин булшнаас олсон байна. Ийм төрлийн чулуун аяга болон шанага Оросын Минусын хотгороос олддог ажээ. Чулуун шанагыг Минусын хотгорынхонтой харьцуулаад МЭӨ X-YIII зуунд,² аягыг бас мөн энэ үед холбогдуулан үзжээ.³ Тэрхүү Минусын хотгорын чулуун эдлэлүүд Монголд хэрхэн ирсэн нь сонирхолтой бөгөөд энэ нь ямар ч байсан энэ 2 соёлын хооронд холбоо байгааг илтгэж байна. Үүнийг:

1. Хоорондоо харилцаж байснаар
2. Тус бүс нутгаас Минусын хотгор, түүнээс цааш нүүсэн нүүдлээр
3. Минусын хотгороос наашаа нүүсэн нүүдлээр
4. Минусын хотгороор дайрч тус бүс нутаг (Дорнод Монгол)-т ирж суурьшсан байж болох Индоиран аймгуудын нүүдлээр
5. 2 бүс нутагт нэг ижил аяга шанага хийх арга барил зэрэг хөгжсөн зэргээр тайлбарлаж боох бөгөөд хамгийн боломжтой хувилбар нь нүүдлийн замаар 2 бүс нутгаас нэг нэгэндээ нөлөөлсөн гэж үзэх нь зүйтэй байна. Энэ дээр цаашдын судалгаа шаардлагатай.



Эцэст нь дүгнэхэд неолит, хүрэл, хүннүгийн булшны аль алинд нас барагчийнхаа ойр зуурын хэрэгцээний эд өлгийг дагалдуулж байгаа бөгөөд энэ нь хойд насандаа дутагдаж гачигдах зүйлгүй тайван амьдрахыг бэлэгдсэн өөрөөр хэлбэл хойд насны тухай хөгжингүй ойлголт байсныг харуулж байна. Неолитоос хүрэл, хүрлээс Хүннүд шилжихэд дагалдуулж буй эд өлөг нь улам баялаг болж байгаа нь нийгэмд гарч буй дэвшлийг харуулж байгаа төдийгүй хойд насны тухай дээрх ойлголт улам бүр гүнзгийрэн лавширч байсныг баталж ба.

5.Зан үйл, шүтлэг бишрэлтэй холбоотой зарим асуудал

Оршуулгын зан үйл нь харилцан холбоотой хоёр хэсгээс бүрдэнэ. Эхнийх оршуулахын өмнө ба оршуулах үе, түүний дараах гэсэн уламжлалт ёслолын үйл ажиллагаагаар тодорхойлогдоно. Уг үйл ажиллагаа нь овог хүйн нас барсан гишүүнийг нөгөө ертөнцөд үдэж явуулахад чиглэсэн байх бөгөөд ураг төрлийнхний

² Д.Эрдэнэбаатар "Асгатын дөрвөлжин булш" АС.т.XIII.ф.4 УБ.1992 (53-61-р тал)

³ Монгол солонгосын хамтарсан эрдэм шинжилгээ-2" 1993 он (130-135-р тал)



Монгол-Солонгосын "Дорнод Монгол" төсөл
Хэнтий аймаг, Цэнхэрмандал сум
Устын амны 1-р дөрвөлжин булш

Зураг.

гүйцэтгэх ажил болно. Хоёр дахь хэсэг нь нас барагчийн нийгмийн байдал ба оршуулгын зан үйлд тохирсон байгууламж эд өлгийн зүйлс, шарилын тавилт зэргээс бүрдэнэ.

Оршуулгын зан үйл нь нийгэм болон угсаатны хөгжил, хөдөлгөөн, өөрчлөлтийг байнга хадгалж байдгийн хувьд эртний аливаа угсаатан, овог аймгуудын шүтлэг бишрэлийг нэхэн хэлэлцэх мэдээллийг агуулж байдаг. Хүн нас барсны хойно манай ертөнцийн амьдралаас огт ялгаагүй нөгөө ертөнцөд мал сүргээ өсгөн үржүүлэх, идэж уух зэргээр амьдрал үргэлжлэх тухай төсөөлөл эртний хүмүүсийн дунд байжээ. Эртний булш оршуулгуудад гоёл чимэглэлийн зүйл, зэр зэвсэг, сав суулга, шавар ваар, хоол хүнс, адуу, үхэр, хонь, ямаа зэрэг нөгөө ертөнцөд амьдрахад зайлшгүй хэрэгцээтэй бүхий эд агуурс, мал сүргийг (толгойн яс зэргээр төлөөлүүлэн) дагуулан оршуулна. Тэрчлэн ээрүүлийн дугуй, хөгжмийн зэмсэг зэрэг амьд ахуйдаа хэрэглэж асан ажил төрөлтэй холбоотой зүйл байгаагаас үзэхэд хойт нас, нөгөө ертөнцийн тухай тогтсон төсөөлөл үүссэн байжээ. Үүнтэй холбоотой судалгааны үед илэрсэн зарим зан үйл, шүтлэг бишрэлтэй холбоотой асуудлуудыг авч үзье.

Неолитийн үед хүнээ оршуулахдаа улаан зос цацах заншил байжээ. Энэ нь цусыг төлөөлүүлсэн зан үйл цус үхсэний онц тэмдэг гэж үзэж байсныг гэрчилж байгаа бөгөөд яг үүнтэй ижил зан үйл хүрлийн үеийн Жэвхээстэй 4, Норовлин 4, Баянцогт 4, Өлзийт уул 16, Ёлын байц 7, Зүүн хар чулуут 1, Эрдэнэ овоо 1-р булш зэргээс харагдаж байгаа бөгөөд энэ нь 2 соёлын хоорондын залгамж холбоог харуулж байгаа юм.

Хүрлийн үеийн булшинд нас барагчдаа дэр ивүүр чулуу тавих заншил байсан нь Жэвхээстэй 4, Дээд өлзийт 19 зэрэг 7 булшинд ийнхүү дэр ивүүр чулуу тавьснаас харагдаж байна. Энэ нь юутай холбоотой заншил болох нь тодорхойгүй бөгөөд Дуулга уулын хүннүгийн нэгэн булшнаас мөн ийм дэр ивүүр чулуу тавьсан зан үйл ажиглагдсаныг дурдсан байна. Мөн нас барагчаа оршуулахдаа гал түлж тахилга үйлдэх ёслол үйлдэж байсны ул мөр хүрлийн булшуудаас нилээд олддогоос гадна галыг төлөөлүүлж 3 чулуу тавих, цахиур, хүлс зэргийг гал орлуулан тавих заншил мөн энэ үед байсан байна. Энэ нь хойд насны ойлголт хөгжиж байсныг баталж байгаа бөгөөд ийм заншил Хүннүгийн булшнаас мөн адил ажиглагддаг байна. Хүннүгийн бараг бүх булшинд гал түлж тахилга үйлдэж байсны ул мөр шатсан нүүрс их хэмжээгээр олддог. Энэ нь хүрлийн үед үүсээд Хүннүд уламжлагдсан заншил бололтой.

Зан үйлтэй холбоотой яригдах нэг асуудал бол шүтлэг бишрэлийн чанартай зарим эд өлгийн асуудал. Неолитийн үеийн Норовлингийн булшнаас саарал өнгийн чулуугаар хийсэн, эрэгтэй хүний нүүрийн дүртэй чулуун онгол олдсон. Энэхүү онгыг хүзүүндээ эсвэл аль нэг газраас зүүж хэрэглэж байсан нь харагдаж байгаа бөгөөд ийнхүү зүүж хэрэглэх нь шүтлэг бишрэлтэй холбоотой эд өлөг байсныг харуулж байж болох юм. Түүнээс гадна хүрлийн үеийн нэгэн булшнаас шувууны толгойн дүрсийг дуурайлгаж хийсэн модон эдлэл олдсон нь хурмастын ямар нэг амьтныг шүтэж байсныг харуулж байгаа бөгөөд энэ бүх баримт нь шүтэж байсан зүйлийг нь оршуулахдаа хамт оршуулж нөгөө ертөнцөд түүнийг хамгаалж байхыг бэлэгдсэн санаа ажиглагдаж байна.

Энэ бүхэн дээрээс үндэслэн үзэхэд эртний хүмүүсийн дунд оршуулах зан үйл нэгэнт бүрэлдэн тогтсон байсныг харж болж байгаа бөгөөд зан үйл, шүтлэг бишрэл, хойд настай холбогдсон зарим асуудал нь өмнөх үеэс дараагийн үед шилжихэд уламжлагдан залгамжлагдаж, цаашилбал шинэ шинэ санаагаар баяжигдан хөгжсөөр иржээ гэж үзэж болно.

Эцэст нь харьцуулсан судалгаан дээрээс үндэслэн неолит, хүрэл, хүннүгийн оршуулгын зан үйл дээр дараах төсөөтэй шинж тэмдэгүүд ажиглагдаж байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Неолит ба хүрэл:

А. Энэ 2 үеийн хооронд байгаа төсөөтэй заншил бол аль алинд нь тааралдаж байгаа зос цацах заншил. Зос нь үхсэний онц тэмдэг цусыг төлөөлүүлэн булшинд хэрэглэдэг байсан заншил бололтой.

Б. Наран ургах зүүн зүгийг аль алинд нь эрхэмлэн үздэг байжээ.

В. Неолитийн үеийн зэвсэг хийх гол түүхий эд болох цахиур, зарим цахиур зэвсэг хүрлийн үеийн булшнаас цөөнгүй гардаг. Энэ нь 1-рт цахиур зэвсэг шахагдан гарч амжаагүй байсан, 2-рт өвөг дээдсийнхээ эд өлгийг хүндэтгэн хадгалдаг зэргээр тайлбарлагдаж байгаа бөгөөд ямартай ч 2 соёлын хооронд ямар нэг холбоо хамаарал байгааг гэрчилж байгаа юм.

Г. Гоёл чимэглэлд нь танан сувс, танан эдлэл аль алинд нь зонхилж байна.

Хүрэл ба Хүннү:

А. Адууны толгой, 4 шийр, тагалцаг нас барагчийнхаа толгойн талд олноор тавих заншил. Энэ нь хүрлийн болон Хүннүгийн хэд хэдэн булшинд тохиолдож байгаа зан үйлийн шинж юм. Жишээ болгож 1993 оны Устын амны 1-р булш, 1997 оны Дэлгэрхааны 1-р булшийг дурдаж болно (Зураг).

Б. Ваар сав дагалдуулах заншил. Хүннүгийн үеийн булшнаас ваарны хагархай олноор олддог бол Хүннүгийн булшнаас олон тооны ваар сав олддог. Энэ нь Хүннүгийн үед ваар саванд хүнс хийж дагалдуулан оршуулах заншил бий болсноор тайлбарлагдана.

В. Галаар тахилга үйлдэх, гал төлөөлүүлэх заншил энэ 2 соёлд аль алинд нь байна.

Г. Хүнээ тэнэгэр байдлаар оршуулах заншлыг энд оруулж болно.

Д. Хүрэл болон Хүннүгийн булшнаас олддог чон чулуун зүүлт ур хийц, хэв маягаараа ойролцоогоос гадна аль алинд нь гоёл чимэглэлд чон чулууг ашигладаг байжээ.

Е. Хүннүгийн үеийн булшнаас 3 хөлт хүрэл хүлс, 4 хөлт хүрэл цар, хүрэл толь зэрэг эд зүйлс гарсан байна. Энэ нь 1-рт өмнөх үйлдвэрлэл хараахан шахагдаж амжаагүй байсан, 2-рт өвөг дээдсийнхээ эд зүйлсийг уламжлан хадгалж ирснээр тайлбарлагдана.

Ж. Гаднах зохион байгуулалт нь хэлбэр төрх нь өөр боловч аль алинд нь газрын хөрснөөс дээш чулуун байгууламж барьж босгодог байжээ. Хүннүгийн дэлгэрхааны 1998 оны 1-р булшнаас хүрлийн үеийн дөрвөлжин булсныхтай төстэй гадаад зохион байгуулалтын онцлогийг харж болно. Хүннүгийн булшинд булшны нүхийг дагуулан том том чулууг дөрвөлжлөн өрж түүн дээгүүрээ чулуу овоолон дугуй хэлбэртэй байгууламж босгодог байсан нь дөрвөлжин булшны соёлоос залгамж холбоотойг харуулж байна.

И. Дуулга уулын 1975 оны 1-р булш, 1998 оны 2-р булшинд нас барагчийг зүүн тийш харуулан оршуулсан нь хүрлийнхтэй төстэй. Ер нь Дуулга ууланд малтсан булшуудын бараг тал хувьд нь Эгийн голын Бурхан толгойд малтсан Хүннү булшууд, Буриадын нутагт малтсан булшуудад нас барагчийн зүүн зүг чиглүүлэн оршуулсан байжээ.

К. Хүрлийн үеийн зарим булшинд ажиглагддаг чулуун хашлага, чулуун таглаас нь Хүннүгийн үеийн чулуун болон модон авс, таглаастай төсөөтэй байгаа бөгөөд түүний эх үүсвэр нь болж өгсөн гэж үзүүштэй. Энэ нь Коноваловын Хүннү булшны анхны хэлбэр нь чулуун хашлагатай дөрвөлжин булш гэж үзсэнтэй тохирч байна. Дэлгэрхааны 3 ч булшинд тааралдаж байгаа том том чулуун дараас нь хүрлийн зарим булшинд байдаг чулуун дараастай төстэй.

Неолит, Хүрэл, Хүннү

А. Газар нутгийн хувьд нийтлэг

Б. Нас барагчаа ойр зуурын хэрэгцээний гоёл чимэг, зэр зэвсэг, хоол хүнс дагалдуулан оршуулж байгаа нь хойд насны тухай ойлголт аль алинд нь бүрэлдсэн байсан гэж үзэхэд хүргэж байна.

В.Антропологийн хэрэглэгдэхүүнээс үзэхэд аль аль нь Монгол төрхтөн, Байгаль орчмын хэв шинжид хамаарахыг¹ хүн судлаач Д.Түмэн тогтоосон.

Н.Сэр-Оджав харьцуулсан судалгаандаа үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийсэн байна.

Неолит хүрлийн үеийг холбож болох нэгэн дурсгал бол төрөл бүрийн сувс юм. Хэрвээ неолитийн үед тусгай зуурмалаар хийсэн бичил сувс тухайлбал Норовлингийн неолитийн булшинд голлож байсан бол, тэр уламжлал хүрлийн үед үргэлжилж байжээ. Үүнд жишээ болгож Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 2-р булш, Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын 3-р булшнаас гарсан сувсуудыг дурдаж болох бөгөөд неолитийн үеийн гоёл чимэглэлийг судлахад нэг ёсны жишээлэл байсан байж болох юм.

Неолитийн үе хүрлийн үе 2 зөвхөн соёлын хувьд ойр холбоотой нэг нэгээ залган авсан төдий бус бүр генетик холбоотой байсан нь антропологийн хэрэглэгдэхүүнээр батлагдаж байна. Дээр дурдсан бүхнийг үндэслэн Монголын неолит, түүнийг залгамжилсан хүрлийн үетэйгээ шууд холбоотой бөгөөд зөвхөн соёл бус угсаа гарлын хувьд үргэлжлэн дамжиж ирсэн юм гэдэг дүгнэлтийг хийж болох бололцоотой болж байна².

Энэ нь неолит ба хүрэл, хүрэл ба хүннүгийн хооронд ямар нэг байдлаар холбоо байсан гэдгийг баталж байгаа ба энэхүү судалгааны явцад оршуулах зан үйл, булшны бүтэц зохион байгуулалтын олон талт төсөөтэй байдлаар батлагдаж байна.

Дүгнэлт

Неолит, хүрэл, хүннүгийн оршуулгын зан үйлийг харьцуулан судалж үзээд дараах дүгнэлтэнд хүрч байна.

Неолитийн үед хөрсөн дээр ил ямар нэг шинж тэмдэггүй, нас барагчийг суугаа байдлаар бохируулан, зүүн зүгт голдуу харуулж, зарим эд өлгийг дагуулан, улаан зос цацан оршуулдаг байжээ.

Хүрлийн үед зориулан бэлдсэн хавтгай чулуунуудыг эгнүүлэн өрж дөрвөлжин засаад, хүнээ зүүн зүг голцуу харуулан тэнэгэр байдлаар тавьж, ойр зуурын хэрэгцээнийх нь эд өлөг, хүнсний зүйлийг дагалдуулан, дэр ивүүр чулуу тавьж, зос цацах, гал түлж тахилга үйлдэх зэрэг зан үйл гүйцэтгэн оршуудаг заншил байсан.

Хүннүгийн үе рүү шилжихэд оршуулах зан үйл илүү нарийн төвөгтэй болж, дугуйвтар цагираг байдлаар чулуу овоолон, чулуун болон модон авс үйлдэж, нас барагчийг хойд зүг голцуу харуулан тэнэгэр байдлаар тавьж, харьцангуй баялаг эд өлөг, хүнсний зүйлсийг дагалдуулан, гал түлж тахилга үйлдэн оршуулах болжээ.

Неолитоос хүрэл, хүрлээс Хүннүгийн үе болж цаг хугацаа өнгөрөх тусам тэдгээрийн оршуулгын зан үйлийн хооронд ялгаа гарч байгаа бөгөөд үүнийг дараах хүчин зүйлүүдээр тайлбарлаж болох юм.

1.Түүхэн цаг үеийн ялгаа

2.Нүүдлийн мал аж ахуй эдийн засгийн гол салбар болсноор түүнд тохирсон

шинэ соёл бий болсон.

3.Нийгмийн хөгжлийн төвшин

4.Хөрш зэргэлдээх газар нутгийн соёлын нөлөө, миграци зэрэг болно.

Дээрх хүчин зүйлүүдийн нөлөөгөөр оршуулгын зан үйлд мэдэгдэхүйц өөрчлөлтүүд гарч байгаа боловч соёлын уламжлал, залгамж холбоо зан үйлийн зарим элемент дээр харагдаж байна гэж үзэж болохоор байна.

¹ Д.Түмэн Этногенез Монголов в свете данных далеоантропологии М. 1985 (стр 16)

² Н.Сэр-Оджав "Монголчуудын эртний түүх" УБ.1977 (33,48-р тал)

Энэ нь 1-рт зос цацах, зүүн зүг эрхэмлэх, гал түлж тахилга үйлдэх, адууны толгой болон бусад ясыг олноор дагалдуулан оршуулах зэрэг зан үйлийн шинж тэмдгээр, 2-рт нас барагчдаа ойр зуурын хэрэгцээнийх нь эд өлөг дагалдуулан оршуулах ба зарим эд өлгийн ойр төсөөтэй байдлаар, 3-рт булшны бүтэц, зохион байгуулалтанд ажиглагдаж байгаа ижил төсөөтэй талууд, эцэст нь антропологи хэв шинжийн хувьд нэг төрхтөн байгаа зэргээр тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл археологи, антроплогийн судалгааны хэрэглэгдэхүүнээс үзвэл неолитийн оршин суугчид, дөрвөлжин булшны соёлынхон болон Хүннү нарын хооронд угсаа гарвалын холбоо байж болохоор байна.

Энэ бүхэн дээрээс үндэслэн үзэхэд эртний хүмүүсийн дунд оршуулгын зан үйл нэгэнт бүрэлдэн тогтоод байсан бөгөөд зан үйл, шүтлэг бишрэл, хойд настай холбогдсон зарим асуудал нь өмнөх үеэс дарагийн үед шилжихэд уламжлагдан залгамжлагдаж, цаашилбал шинэ шинэ санаагаар баяжигдан хөгжсөөр иржээ.

Н.Сэр-Оджав "Монголын неолит, түүнийг залгамжилсан хүрлийн үетэйгээ шууд холбоотой бөгөөд зөвхөн соёл бус угсаа гарлын хувьд үргэлжлэн дамжиж ирсэн. Дөрвөлжин булш үлдээгсэд Хүннү нарын бүрэлдэхүүнд багтан орсон, зарим хэсэг нь ууссан. Хүннү нарын гол цөм нь Монгол хэлтэн аймаг байсан гэж үзвэл Монголчуудын гарал угсааг дөрвөлжин булшны соёлоос эрж хайх нь зүйтэй байна¹ гэж үзсэнтэй судалгааны үр дүн тохирч байна.

Харин неолитоос Хүннүгийн оршуулгын зан үйлд шууд нөлөөлсөн гэж болохоор шинж тэмдэг цөөхөн байна. Эндээс харвал хүрлийн соёл нь өмнөх болон дараах үеийн 2 соёлынхоо аль алиных нь зарим шинжийг агуулж байгаа нь завсрын соёлд зайлшгүй байх шинж бөгөөд цаг хугацааны өөрчлөлт нь хөгжил дэвшлийн гол хүчин зүйл болж байгааг харуулж байна.

Ном зүй

Батсайхан З. Умард Хүннү ба нүүдлийн иргэншлийн хөгжил. МУИС.2000 Докторын (Ph.D) дисс.

Баяр Д. Дуулга уулын нэгэн булш. АС.т.VII.ф.6.УБ. 1976

Волков В.В. Бронзовый и ранний железный век на Северной Монголии. УБ. 1967

Дорж Д. Неолит Восточной Монголии. УБ.1971

Дорж Д., Окладников А.П., Ларичев В.Е. Новые материалы по неолиту Восточной Монголии. Монголын эртний түүх соёлын зарим асуудал. Том V., УБ. 1972

Доржсүрэн Ц. Умард Хүннү. УБ.1961

Доржсүрэн Ц. Хойд Хүннүгийн булш. ШУХЭШБ №8, УБ. 1956

Киселёв С.В. Древняя история Южной Сибири. М. 1951

Монгол Солонгосын хамтарсан эрдэм шинжилгээ-3. УБ. 1993

Наваан Д. Дорнод Монголын хүрлийн үе" УБ. 1975

Наваан Д. Эртний Монголын түүхийн дурсгалууд. УБ. 1980

Окладников А.П. Неолит и Бронзовый век Прибайкалья. М.1955

Руденко С.И. Культура Хуннов и Ноинулинские курганы. М.Л. 1962

Сүхбаатар Г. Монголчуудын эртний өвөг. УБ. 1981

Сэл-Оджав Н. Монголчуудын эртний түүх. УБ. 1977

Түмэн Д. Вопросы этногенез Монголов в свете данных палеоантропологии.

Канд.дис М. 1985

Цэвээндорж Д. Монголын хүй нэгдлийн урлагийн дурсгал. УБ. 1983

Эрдэнэбаатар Д. Асгатын дөрвөлжин булш. АС.т. XIII.ф.4. УБ. 1992

¹ Н.Сэр-Оджав "Монголчуудын эртний түүх" УБ. 1977 (33,48-р тал)

Summary

G.Batkhashig

Comparative study of burial patterns and rituals of ancient nomads from different historical periods of Eastern Mongolia

Burial rituals of 5 Neolithic, more than 80 bronze age and 11 Xiongnu period graves were studied. Comparing burial traditions practiced in different historical periods of Mongolia we found that there are more differences between them further from Neolithic period. These differences can be explained by historical diversities, social development, migration and influence of neighboring cultures. As animal husbandry became main branch of the economy, culture of ancient nomads developed adjusting to their subsistence economy. At the same time there are several traits showing strong relationship between subsequent historical periods, such as painting burial pit with ochre, favoring the East, sacrificing with fire, including horse head or other animal bones and other utensils in the burial, and similarity in grave structure.